

НИЙСЛЭЛИЙН ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР

СХ№ 39 .

ТҮҮХЧИЛСЭН ДАВЛАХ

Улаанбаатар хот
2012 он

АГУУЛГА

1. Нийслэлийн Хөдөө аж ахуйн газрын нэрийн өөрчлөлтийн жагсаалт
2. Нийслэлийн Хөдөө аж ахуйн газарт ажиллаж байсан удирдлагуудын нэрсийн жагсаалт
3. Газрын үүсч хөгжсөн түүх
4. Хөмрөгийн түүх
5. Товчилсон үгийн жагсаалт

НИЙСЛЭЛИЙН ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН
НЭРИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ЖАГСААЛТ

2012.10.18

№	Огноо	Нэрийн өөрчлөлт
1	1923 он	Нийслэл хүрээний мал эмнэлэг
2	1972 он	Хотын хөдөө аж ахуйн хэлтэс
3	1977.06.17	Хотын хөдөө аж ахуйн удирдах газар
4	1990 он	Хотын хөдөө аж ахуйн хүнсний үйлдвэрлэлийг удирдах газар
5	1992.09.11 1997.01	Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газар
6	2005.01.26 2008.12.23	Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Хүнс, хөдөө аж ахуйн газар
7	2008.12.24 Одоог хүртэл	Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Хөдөө аж ахуйн газар

НИЙСЛЭЛИЙН ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАРТ
АЖИЛЛАЖ БАЙСАН УДИРДЛАГУУДЫН НЭРС

2012.10.18

№	Огноо	Удирдлагаар ажиллаж байсан хүмүүсийн нэрс
1	1923 он	П.Жүрмэд
2	1972-1986он	Н.Батсүмбэр
3	1986-1988 он	Б. Хөххүү
4	1988-1990 он	Ц.Мижиддорж
5	1992-1997 он	Г.Төмөрбаатар
6	2005 оноос одоог хүртэл	Р.Зоригт

НИЙСЛЭЛИЙН ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР ҮҮСЧ ХӨГЖСӨН ТҮҮХ

2012.10.18

Монгол улсын нийслэлийг Улаанбаатар гэж тунхагласан цагаас хотын төр захиргааны байгууллага нийслэлийн хүн амын хүнсний хангамжийг сайжруулах, хөдөө аж ахуйг хөгжүүлэх цэгцтэй алс хэтийн хараатай бодлого барьж түүнийгээ хэрэгжүүлж ирсэн түүхтэй.

Улаанбаатар хотын захиргаа 1925 онд байгуулагдаж 13 хороотой байснаа 1926 онд хороогоо 9 болгон цөөлж хотын хүн ам нь 30, 000 хүрч мал сүрэг нь 5000 орчим байжээ.

Энэ үед монгол улсын мал сүрэгт хамуу, үхрийн мялзан, боом, цээж, шүлхий, ямааны годрон, адууны ям, хонины цэцэг зэрэг элдэв халдварт өвчин өргөн тархсан дан ганц нутгийн үйлдвэрийн давжаа биетэй ашиг шимийн гарц багатай мал зонхилж, мал эмнэлэг, малын үржлийн алба бий болоогүй байлаа.

Малын дээрхи өвчнүүд Улаанбаатар хотын иргэдийн амины мал сүрэгт нэгэн адил байсан бөгөөд 1923 онд засгийн газрын шийдвэрээр байгуулагдсан дотоод яамны мал эмнэлгийн хэрэг эрхлэх газрын дэргэд нийслэл хүрээний мал эмнэлэгт П. Жүрмэд гэдэг хүнийг даргаар нь томилж, сургагч даргаар нь малын их эмчийн П.И.Орловыг сургагчаар, А.А.Дудуколовыг малын их эмчээр томилон 12 хүний орон тоотой ажиллуулсан нь Нийслэл хотын хөдөө аж ахуйн ууган байгууллага байсан юм.

Улсын болоод нийслэлийн мал эмнэлэгийн алба төлөвшиж малын элдэв халдварт өвчинтэй хүчтэй тэмцэж ирснээр 1929, 1930-аад оны үед Улаанбаатар хот түүний орчмын мал сүрэгт гардаг хурц халдварт өвчний гаралт үндсэндээ зогсож, эрүүлжин, тоо толгой нь өсөх хандлагатай болжээ.

Нийслэлийн мал эмнэлгийн алба хот орчмын мал сүргийг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх, золбин ноход муурыг устгуулах, мал амьтны гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд шинжилгээ хийх зэрэг ажил үйлчилгээг эрхлэн гүйцэтгэж мэргэжлийн боловсон хүчнээр бэхжин шинэ техник тоног хэрэгслээр хангагдсан орчин үеийн мал эмнэлэг болтлоо хөгжсөн байна.

Улаанбаатар хотын мал эмнэлгийн албыг өнгөрсөн хугацаанд анхны Монгол эмч П.Жүрмэд, ахмад эмч Б.Бааст, Х.Лувсансамбуу, Ж.Идэрборгил, Н.Лхагвасүрэн нар тус тус удирдаж хотын мал амьтдыг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх ажилд амжилт гаргаж нийслэлийн хүн амыг эрүүл хүнсээр хангаж, мал эмнэлгийн албаны материаллаг баазыг бэхжүүлж,

мэргэжлийн боловсон хүчнээр хангахад үнэтэй хувь нэмэр оруулсан гавъяатай хүмүүс юм.

1970-аад он гэхэд төр засгаас авч хэрэгжүүлсэн олон талт арга хэмжээний дүнд хот, суурин газрууд эрчимтэй хөгжиж, мал аж ахуйд шинжлэх ухааны нээлт ололтыг нэвтрүүлэх, малын үйлдвэр угсааг нь сайжруулах, ашиг шимийг нь нэмэгдүүлэх ажилд ахиц гарч газар тариалан, хөдөө аж ахуйн бие даасан салбар болон хөгжиж, хүн амын өсөн нэмэгдэж байгаа хүнсний хэрэгцээг хангахад шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх болсон байна.

Энэ цаг үед Нийслэл хот хаяагаа тэлэн түргэн хөгжиж, хүн ам өсч, хүн амын хоол хүнсний бүтцэд өөрчлөлт гарч, мах сүү, гурилан бүтээгдэхүүнээс гадна гахай, шувууны мах, өндөг, хүнсний олон нэр төрлийн ногоог өргөн хэрэглэдэг болсон нь энэ төрлийн бүтээгдэхүүнээр хот өөрийгөө хангах шаардлага бий болсон юм.

Ийм учраас хөдөлмөрчдийн хэрэгцээг хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнээр хангах ажлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий хотын хөдөө аж ахуйн хэлтсийг БНМАУ-ын сайд нарын зөвлөлийн 1972 оны 232 дугаар тогтоолоор байгуулж, даргаар нь Н.Батсүмбэрийг томилж, харъяанд нь хүнсний ногооны Амгалангийн сангийн аж ахуй, 1964 онд байгуулагдсан 30 мянган өндөглөгчтэй шувуун фабрик, 1971 онд байгуулагдсан 500 мэгжтэй гахай бордох завод, сүүний чиглэлийн Гачууртын САА, хотын мал эмнэлгийн тасаг, хүнсний ногооны зоорь, агуулахууд, хүнсний захууд харъяалагдах болсоноор Улаанбаатар хотод ХАА-н бие даасан салбар үүссэн түүхтэй.

Жил ирэх тутам нийслэл хотын хүн ам өсөж ХАА-ын бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ нэмэгдэж байгаад дүгнэлт хийж дотоод нөөц бололцоог дайчлан саалийн механикжсан 400-800 үнээний 6 фермийг нийслэлд анх удаа хот орчимд барьж ашиглалтанд оруулсан,

Сайд нарын зөвлөлийн 1976 оны 429-р тогтоолоор сүүний чиглэлийн Партизаны САА-г шинээр байгуулж улмаар сүүний гарц нэмэгдүүлэхэд чухал үүрэгтэй даршны ургамал /наран цэцэг, овьёс, вандуй, арвай/ хольж 20-25 мянган га атар хагалж тариалсанаар жилд 30 орчим мянган тн даршны ургамал хураан авч байсан нь сүүний гарцыг эрс нэмэгдүүлж өдөрт 20-25 мянган литр сүүг өөрийн аж ахуйгаас нийлүүлж байлаа.

Мөн төмс хүнсний ногооны хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор 1973-1978 онуудад ногоо хадгалах 1000-1500 тонны багтаамж бүхий 60 зоорийг шинээр барьж БНАГУ-ын техник эдийн засийн тусламжаар 1978 онд 16 мянган тонны хүчин чадалтай, механикжсан зоориуд баригдаж жилд дунджаар 35-40 мянган тонн төмс 25-30 мянган тонн хүнсний ногоо хүлээн авч ялган савлаж зоорилох ажилд

жил бүрийн намар 2000-3000 оюутан ажиллуулж зоорилолтын ажлыг хийдэг байлаа.

БНМАУ-ын сайд нарын зөвлөлийн 1976 оны 171-р тогтоолоор ногооны комбинатыг байгуулж төмс хүнсний ногоо хадгалах 76 зоорь бүхий хадгаламжийн 5 анги салбарыг хариуцуулан хотын хөдөлмөрчдийг жилийн турш дараа жилийн ургац хүртэл төмс хүнсний олон нэрийн ногоогоор хангаж, Сайд нарын зөвлөлийн 1976 оны 187-р тогтоолоор хоёрдмол удирдлагатай “Сүү, төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийн нэгдэл байгуулж Төв аймгийн Батсүмбэр, Борнуур Октябрь, Баянчандмань, Баянцогтын САА, Сэлэнгэ аймгийн Баруун хараа, Зүүн хараагийн САА-уудын үйлдвэрлэлийг нь хариуцан 2 жил гаруй ажиллаад татан буугдаж, Улаанбаатар хотын бүсийн аж ахуйнууд болгон бүтээгдэхүүнийг нь Хотын хөдөө аж ахуй удирдах газар хариуцан хүлээн авдаг байсан.

Мөн нарийн ногооны “Дэвшил” САА-г 1978 онд байгуулж БНБАУ-ын техник эдийн засгийн тусламжтай баригдсан 6 га шилэн хүлэмж, өөрийн хөрөнгөөр баригдсан 18 га хүлэмж, дарлагаар Улаан лооль, өргөст хэмх, эрт ургацын байцаа, лууван бусад нарийн ногоог тариалж нийслэл хотын хөдөлмөрчдийн хэрэгцээнд 3000 гаруй тонн витаминлаг шинэ ургацын ногоог тасралтгүй нийлүүлж ирсэн юм.

БНГАУ-ын техник тоног төхөөрөмж эдийн засгийн тусламжаар баригдсан ногоо дахин боловсруулах цехээр байцааг давслаж дарах, төмс, лууван, манжинг дахин боловсруулж нийслэл хотын нийтийн хоолны газруудад нийлүүлж хэрэгцээг нь бүрэн хангаж байлаа. 30 мянган өндөглөгчтэй шувууны фабрикыг 100 мянган өндөглөгчтэй болгож өргөтгөснөөр жилд 100 гаруй сая ширхэг өндөг, 25 гаруй тонн мах мөн 500 мэгжтэй гахай бордох заводыг 1000 мэгжтэй болгон өргөтгөснөөр жилд 500 гаруй мянган тонн гахайн махыг нийслэлийн хөдөлмөрчдын хэрэгцээнд нийлүүлж байжээ.

Жил ирэх тутам нийслэл хотын хүн ам өсч ХАА-н бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ нэмэгдэж түүний үйлдвэрлэлт, нийлүүлэлтийн хэмжээ ихсэж хотын харьяа Аж ахуйнаас гадна Төв, Сэлэнгэ аймгийн 20 гаруй САА, ХАА-н нэгдэл 20 гаруй саалийн механикжсан фермүүдээс сүү, төмс хүнсний ногоо хүлээн авч Улаанбаатар хотын сүүний үйлдвэр, хүүхдийн сүүн тэжээлийн үйлдвэр, ногооны комбинат, түүний харьяа ногоо хадгалах 5 аж ахуйд хүлээн авч нийслэлийн хөдөлмөрчдөд үйлчилж байлаа. ХАА хөгжүүлэх хүн амын хүнсний хангамжийг сайжруулах, зорилтот программын хүрээнд нийслэлийн албан байгууллага, ард иргэдийн амны туслах аж ахуй хөгжүүлэх говь хээрийн бүсийн 100 гаруй ХАА-н нэгдлүүдийг нийслэл хотод үйл ажиллагаа явуулж байгаа төрийн яам, тусгай газар, үйлдвэр аж ахуйн газруудтай шифлүүлэн байнгын холбоо харилцаатай

ажиллуулан, байгаль цаг уурын хүндрэлтэй үеүүд, төл бойжуулах ажилд нь туслуулж үр дүнг нь тооцох, намрын ургац хураалтын үед хотод төмс хүнсний ногоо нийлүүлдэг САА-уудад хүн хүч, машин тээврийн туслалцаа үзүүлэх, мөн хотын Гачуурт, Партизаны САА-д хадлан, дарш бэлтгэх ажилд яам тусгай газрууд болон нийслэлийн албан байгууллагуудыг туслалцуулан, хадлан өвсний төлөвлөгөө өгч түүний биелэлтэнд хяналт тавих, дүгнэлт зэрэг ажлуудыг хотын ХАА-н удирдах газар хариуцан гүйцэтгэж байлаа.

Хотын ХАА-н хэлтсийн хариуцах ажлын хүрээ өргөжсөн учир БНМАУ-ын сайд нарын зөвлөлийн 1977 он 6-р сарын 17-ны өдрийн 183-р тогтоолоор хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны ХАА-н хэлтсийг хотын ХАА удирдах газар болгон даргаар нь Н.Батсүмбэрийг улируулан томилсон байна.

Нийслэл Улаанбаатар хотын хүн амыг сүүгээр хангах асуудал, төр засгийн байнгын анхааралд байж улсын хэмжээнд 20 гаруй саалийн механикжсан фермүүдийг байгуулж тэдгээрт ЗХУ, БНАГУ-аас сүүний чиглэлийн симентал, хар тарлан, сүү махны чиглэлийн алтай үүлдрийн үнээ гунж авчирч үржүүлэн сүүний үйлдвэрлэл хангамжинд эргэлт гаргаж нийслэл хот, Төв Сэлэнгэ аймгуудын САА, ХАА-н нэгдлүүдийн саалийн механикжсан болон энгийн 55 ферм аж ахуйн нэгжээс Улаанбаатар хотын сүүний үйлдвэрт хоногт 60 шахам сая литр сүү нийлүүлж нийслэл хотын хөдөлмөрчдийн хэрэгцээ ялангуяа өндөр настан, 0-8 насны хүүхдийг сайн чанарын витамин уураг, тослог сайтай экологийн цэвэр эрүүл хоол тэжээл сүү, тараг, цөцгий, ааруул, аарц зэрэг бүтээгдэхүүнээр 1990 оныг хүртэл бүрэн хангаж байлаа. Үүний зэрэгцээ хүүхдийн сүүн тэжээлийн үйлдвэр, сульдаатай болон тэжээвэр хүүхдүүдэд зориулан 10 гаруй нэр төрлийн витаминлаг хоол тэжээл үйлдвэрлэж, 20 шахам цэгээр эх нялхаст тогтмол үйлчилж байсан нь хүүхдийн өсөлт торнилтыг сайжруулах, эндэгдлийг бууруулсан чухал арга хэмжээ байсан юм.

1980-аад оны сүүлийн хагас буюу 8-р таван жилийн төлөвлөгөөг ханган биелүүлэх ажил улс орон даяар эрчимтэй өрнөж хүн амын хүнсний хангамжийг сайжруулахад төр засгаас түлхүү анхаарч БНМАУ-ын сайд нарын зөвлөлийн 1990 оны 161-р тогтоолоор Улаанбаатар хотод ажиллаж байсан архи пивоны комбинат, талх болон чихэр боовны үйлдвэр, талх чихрийн комбинат, сүүний үйлдвэр, хүүхдийн сүүн тэжээлийн үйлдвэрүүд Улаанбаатар хотын захиргааны харъяанд шилжин ирсэнээр хотын захиргааны 1990 оны 94-р тогтоолоор Улаанбаатар хотын ХАА-г удирдах газрыг хүнсний мэргэжлийн боловсон хүчнээр орон тоог нь нэмэгдүүлэн хэлтэсгүй бүтэцтэйгээр хотын ХАА-н хүнсний үйлдвэрлэлийг удирдах

газар болгон өргөтгөн зохион байгуулж даргаар нь Ц.Мижиддоржийг томилон ажиллуулсан байна.

Энэ үеэс Улаанбаатар хот хүн амынхаа хүнсний хангамжийн асуудлыг бүхэлд нь өөрөө хариуцдаг болж хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанд үйлдвэрлэл үйлчилгээ хариуцсан орлогч даргын орон тоог шинээр бий болгож Л.Жавзмааг томилон ажиллуулжээ.

1990 оныг хүртэл хүнс, ХАА-н салбарт оруулах хөрөнгө оруулалт жил ирэх тутам нэмэгдэн эрчимтэй хөгжиж харъяа Гачуурт, Партизаны САА-н нийт үхэр сүүний чиглэлийн хар тарлан үүлдрийн цэвэр болон түүний эрлийз үхэр болон сайжирч шувуу фабрик, архи пивоны болон талх чихрийн комбинатууд талхны үйлдвэр техник технологийн шинэчлэлт хийж, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэгч өсч, нэр төрөл нь олширч, нийслэлийн хөдөлмөрчдийн өргөн хэрэгцээний хүнсний бараа, бүтээгдэхүүний хангамж эрс сайжирч байлаа.

Улаанбаатар хотын хүнсний үйлдвэрүүд, нийтийн хоолны газруудыг болон хүн амын хэрэгцээг эх орны үйлдвэрийн гурилаар хангах талаар төр засгаас авсан арга хэмжээний дүнд Улаанбаатар хотын гурилын үйлдвэрийн тоног төхөөрөмжийг шинэчлэн, улаанбуудай хадгалах элеваторыг өргөтгөж, хүчин чадлыг нэмэгдүүлснээр нийслэл хотын хэрэгцээт гурилын 80 шахам хувийг нийлүүлж, дутагдах гурилыг аймгуудын гурилын үйлдвэрээс авч, дотоодын үйлдвэрийн гурилаар үндсэндээ хангаж байсан юм.

Тус гурилын үйлдвэр жилд 7000 шахам тн хивэг үйлдвэрлэн хот орчмын саалын механикжсан фермүүдийн үхрийн тэжээлд нийлүүлж байсны дээр зарим жил ургац элеваторт багтахгүй 43-90 шахам мянган тн буудай стадион болон хатуу хучилттай ил талбайд хүлээн авч төрийн яамд, хотын албан байгууллагуудад хариуцуулан хатаалгадаг байсны дээр улаанбуудай, хүнсний гурилыг гадаадад экспортлож байсныг тэмдэглэж байна.

Хөдөө аж ахуйг хөгжүүлэх, хүн амын хүнсний хангамжийг сайжруулах зорилтот праграммын хүрээнд нийслэл хотод 1988 оны эцсээр 342 үйлдвэр аж ахуйн газар, байгууллага, 40937 айл өрх туслах аж ахуй эрхлэн тэдгээрт 72701 толгой мал, 23464 гахай, 3794 шувуу, 5580 туулай, 7425м² талбайтай 93 хүлэмж, ногоо хадгалах 1320 куб.метр багтаамжтай 4564 зоорь ашиглагдаж байлаа.

Туслах аж ахуйгаас 650, 6 тн гахайн мах, амьдын жингээр 2621,4 тн малын мах, 5422,3 тн сүү, цагаан идээ үйлдвэрлэж, 2503,5 тн төмс, 1836,5 тн хүнсний ногоо хураан авч албан байгууллагууд ажилчдынхаа цайны газар, пионерын зусланд болон ард иргэд хоол хүнсэндээ хэрэглэсэн нт нийслэлийн хүн амбн хүнсний хангамжинд бодитой хувь нэмэр оруулж, туслах аж ахуй эрхэлдэг байгууллага

иргэдийн тоо, үйлдвэрлэлийн хэмжээ нь жил ирэх тутам өсч, эрчимтэй хөгжиж байлаа.

Улаанбаатар хотын хүн амын хүнсний хэрэгцээг хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнээр хангах талаар МАХН-ын төв хороо, Сайд нарын зөвлөл, Улаанбаатар хотын намын хороо, АДХ-ын Гүйцэтгэх захиргааны удирдлагууд ихээхэн анхаарч тал бүрийн арга хэмжээ авч, өдөр тутмын үйлдвэрлэлт, нийлүүлэлт, хангалтад хяналт тавин ажилладаг байсныг дурдахад таатай байна. Монгол Улсын Засгийн Газрын 1992 оны 09-р сарын 11-ний өдрийн 25 дугаар тогтоолоор Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газар байгуулагджээ.

Тус байгууллагын гол зорилго нь:

Хүнс, Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг зах зээлийн харилцаанд шилжүүлэх, үйлдвэрлэлийн уналтыг зогсоож хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, технологийн бодлогыг хэрэгжүүлэх зорилготой ажиллаж байжээ. Тус байгууллагын бүтэц нь 9 орон тоотой. Хүнсний мэргэжилтнээр А.Отгон, Б.Адьяа нар, Агрономичоор Г.Чаминчулуун, Мал зүйчээр Н.Лхагвасүрэн, Нягтлан бодогчоор Б.Цэрмаа, бичээч няраваар Л.Эрдэнэцэцэг, жолоочоор Г.Сүрэнхорлоо нар ажиллаж байжээ.

Тус газрын зорилт нь :

- ХХАА-н үйлдвэр компаниудыг зах зээлийн эдийн засгийн харилцааны нөхцөлд санхүү эдийн засгаар бие даан ажиллах чадвартай болгох.
- Төрийн өмчтэй ХАА-н компаниудыг бүрэн хувьчилж дуусгах, хотын санхүү болон арилжааны банкнаас авсан зээлийн өрийг барагдуулах, хадгалах ногоогоо өөрсдөө тариалдаг болгож, зоорины ашиглалтыг сайжруулах.
- Мал аж ахуй газар тариалангийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар нийслэлийн хүн амын хүнсний хэрэгцээний тодорхой хэсгийг өөрсдөө хангадаг болгох.
- Нийслэлийн хүнсний үйлдвэрүүдийг түүхий эдээр найдвартай хангаж, орчин үеийн дэвшилтэт технологи нэвтрүүлэх замаар баталгаатай хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх.
- Нийслэлийн хүн амын хүнсний хангамжийн талаар судалгаа дүгнэлт гаргаж, цаашид шийдвэрлэх асуудлын талаар бодлого чиглэл боловсруулж хэрэгжүүлэх зэрэг зорилтуудыг тавин ажиллаж байжээ. Тус газар нь 1997 оны 1 дүгээр сард татан буугдсан байна.

Хотын Хөдөө аж ахуй хүнсний үйлдвэрийг удирдах газарт мэргэжлийн өндөр мэдлэг чадвартай, ажлын баялаг туршлагатай боловсон хүчнүүд ажиллаж

тэдгээрээс агрономч Б.Идэш, ХАА-н инженер А.Балдан, ня-бо эдийн засагч Ш.Цээпэл, ХААУГазрын орлогч дарга М.Гөлөгөө, Г.Энхболд, хүнсний технологч инженер Г.Гантөмөр, А.Отгон нар идэвхи зүтгэл үр бүтээл гарган сайн ажиллаж байлаа.

Нийслэл хотын хөдөө аж ахуйн салбарт хамт олноо хошуучлан ажиллаж, олон залуу ажилчдыг дагалдуулан сургаж тэднийг халамжлан хүмүүжүүлж, ажил амьдралын баялаг туршлагаа өвлүүлж эзэмшүүлсэн Монгол улсын хөдөлмөрийн баатар саальчин Г.Зиинаа, С.Надмид, С.Хандсүрэн нар болон улсын аварга саальчин Д.Цэрэн, М.Зандан, Ө.Чогжмаа, Ш.Тогоо, Н.Бааст, А.Чулуун, Монгол улсын хөдөлмөрийн баатар шувуучин Дэнсмаа, гахайчин Пэлжидмаа, улсын аварга ногоочин Б.Баянтүмэн, нарын хөдөлмөрийн сайчуудаараа хотын хөдөө аж ахуйн хамт олон бахархан байдаг билээ.

Мөн харьяа САА, хүнсний үйлдвэрүүдэд Удирдах, зохион байгуулах ажлын арвин туршлагатай шилдэг олон удирдах ажилтнууд ажиллаж нийслэлийн хүн амыг хүнс хоолоор хангах ажилд жинтэй хувь нэмэр оруулан хамт олныхоо нийгмийн асуудлыг үлгэр жишээ шийдвэрлэн ажиллаж байлаа. Д.Пүрэвдорж, Гачууртын САА-ын даргаар 1961-1971 онд ажиллахдаа нийслэлийн хүн амыг сүүгээр хангах асуудлыг зорилгоо болгож, саалийн 10 гаруй фермийг шинээр зохион байгуулж тохилог хашаа байраар хангаж, САА-гаа аж ахуйн зохион байгуулалтын хувьд бэхжүүлж хадлан авах, дарш бэлтгэх, ногоон тэжээлийн ургамал тарих ажлыг эхлэн хийлгэж эвсэг, бүтээлч хамт олныг бүрдүүлэн төлөвшүүлсэн ахмад удирдах ажилтан байлаа.

Мөн Амгалангийн САА-н дарга С.Дагвашадав, Гачууртын САА-н дарга А.Далхжав, Партизаны САА-н дарга Ц.Мижиддорж, Ё.Шагдарсүрэн, Дэвшил САА-н дарга Ш.Орсоо, Ногооны комбинатын дарга Б.Нямжав, Н.Батсүмбэр, Шувууны фабрикийн дарга Д.Цэдэнгончиг, Д. Пүрэвдорж, Гахай бордох заводын дарга Г. Бадамдорж, Талхны үйлдвэрийн дарга Ж.Сайнжаргал, Архи пивоны комбинатын дарга Б.Гантөмөр, Сүүний үйлдвэрийн дарга Х.Магсаржав, Т.Дамдинсүрэн нарын зэрэг авьяаслаг дурсагдах гавьяатай удирдах ажилтнуудаа бахархан дурсаж байна.

1990 онд ардчилсан хувьсгал гарч Монгол улсын нам төвтэй төрийн тогтолцоо, төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн харилцаанаас татгалзан төр төвтэй парламентын засаглал бүхий олон намын системтэй улс төрийн тогтолцоот зах зээлийн эдийн засгийн харилцаанд эргэлт буцалтгүй шилжиж төрийн өмчийг хувьчилах ажил 1991 оноос хот, хөдөөд эрчимтэй явагдаж, үйлдвэрүүдийн түүхий

эд материал хангамжийн тогтолцоо алдагдаж, бүх үйлдвэрлэл, үйлчилгээ зогсож улсын эдийн засаг гүнзгий хямралд орсон юм.

Энэ үйл явц хотын хөдөө аж ахуйн салбарыг нэгэн адил хамарч хотын сангийн аж ахуй, түүний саалийн механикжсан фермүүд, сүүний чиглэлийн цэвэр үйлдвэрийн болон эрлийз үнээнүүд хувьд очин устаж, хүнсний үйлдвэрүүд зогсон, олон зуун ажилчид ажилгүй болж нийслэлийн хүн амын хүнсний хангамж уналтанд орж, гурил будаа, мах, талх архи зэрэг гол нэрийн хүнсний бүтээгдэхүүн картын системд орсон жилүүдийг (1990-1993) манай хойч үе мартаж өсгүй.

Дэвшил САА, шувууны фабрик, Талх чихэрийн комбинат, сүүний үйлдвэрийг хувьчилж авсан хүмүүс үйлдвэрлэлийн чиглэлийг нь өөрчлөлгүй хэвээр хадгалан ажиллуулсан нь эзнээ олсон зөв сонголт байсан бөгөөд одоо эдгээр үйлдвэрүүд техник технологийн шинэчлэл хийж сэргэн ажиллаж байна.

Сүүний чиглэлийн Гачуурт, Партизаны САА-нууд хүүхдийн сүүн тэжээлийн үйлдвэр гахай бордох заводыг хувьчлалаар авсан хүмүүс үйлдвэрлэлээ сэргээж хэвийн ажиллуулж чадалгүй устгасан нь ажилгүйдлийг нэмэгдүүлж, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэр төрлийг бууруулсан зохисгүй буруу үйл ажиллагаа болсон юм.

Нийслэлийн хүнс, хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх бодлого барьж, мэргэжлийн удирдлагаар ханган ажиллаж ирсэн хотын хөдөө аж ахуй хүнсний үйлдвэрлэлийг удирдах газрыг Нийслэлийн засаг даргын 1997 оны А-20 тоот захирамжаар татан буулгаж нийслэлийн засаг даргын дэргэдэх захирагчийн ажлын албаны үйлдвэрлэл үйлчилгээний хэлтэст үндсэн үүргийг нь хариуцуулсан байна.

Уг хэлтэст хүнсний үйлдвэрлэл, мал аж ахуй, газар тариалан хариуцсан ганц ганц мэргэжилтэн ажиллуулснаар нийслэл хотод шинэ тутам бий болсон хувийн хэвшлийн мал аж ахуй газар тариалангийн болон хүнсний үйлдвэрлэлийг мэргэжлийн удирдлагаар хангаж дэмжих, үйлдвэрлэлийн төрөл чиглэлийг нь нийслэлийн хүн амын өсөн нэмэгдэж байгаа эрэлт хэрэгцээтэй уялдуулан алс хэтийн чиглэлтэй хөгжүүлэх цогц бодлого алдагдаж, үйлдвэрлэл урсгалаар явагдах гаж тогтолцоог бий болгосон оновчтой бус шийдвэр байсан нь амьдралын явцад тогтоогджээ.

Үүний эцсийн үр дүн нь 2005 он гэхэд нийслэл хотод хөдөө аж ахуйн болон хүнсний аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, нийлүүлэлт түүний чанар, ариун цэвэр, эрүүл ахуйн байдал зах зээлийн харилцаанд шилжихийн өмнөх 1990 оны түвшинд хүрч чадаагүй, хадгалах хугацаа нь хэтэрч муудсан, элдэв химийн хорт бодис, хортон шавьжтай, хуурамч, баталгаагүй хүнсний бүтээгдэхүүнийг импортоор их хэмжээгээр оруулах явдал ердийн үзэгдэл болсон юм.

Хүн амаа экологийн цэвэр хүнсээр хангаж байсан үйл ажиллагаа алдагдан үндэсний аюулгүй байдалд муугаар нөлөөлөхүйц түвшинд хүрч ард иргэдийн сэтгэлийг зовоосоор байна. Монгол Улсын засгийн газраас дээрх байдалд дүгнэлт нийж Улсын мэргэжлийн хяналтын албыг байгуулж, импортоор оруулж байгаа хүнсний бүтээгдэхүүний чанарт болон эрүүл ахуй ариун цэврийн байдалд тавих хяналтыг чангатгаж, хүнсний үйлдвэрлэлийг сэргээж эрчимтэй хөгжүүлэх бодлого барьж эхэлсэн юм.

Нийслэл хот орчимд эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан хөгжүүлж нийслэлийн хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр хангах бодит шаардлагыг харгалзан Монгол Улсын Засгийн Газрын 2005 оны 15 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2005 оны 22, 41 тоот захирамжуудыг тус тус үндэслэн Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг **Хүнс, Хөдөө Аж Ахуйн Газрыг** Хүнс, Эрчимжсэн мал аж ахуй, Газар тариалангийн гэсэн 3 хэлтэс 15 хүний орон тоотойгоор дахин шинээр байгуулж даргаар нь Р.Зоригтыг томилжээ.

Нийслэлийн Засаг даргаас хүнс, хөдөө аж ахуйн салбарын асуудлаар шийдвэр гаргах хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, биелэлтийг хангуулах үүрэг бүхий Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг юм. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Үйлдвэрлэл үйлчилгээний хэлтсээс холбогдох мэргэжилтнүүдийг шилжүүлэн ажиллуулсан байна.

1. Үйлдвэрлэл үйлчилгээний хэлтсийн дарга Ш.Гантөмөрийг орлогч даргаар
2. А.Отгоныг Хүнсний хэлтсийн мэргэжилтэнээр
3. Г.Золбоог Хүнсний хэлтсийн мэргэжилтэнээр
4. Д.Баярсайханг Эрчимжсэн мал аж ахуйн хэлтсийн мэргэжилтэнээр тус тус шилжүүлэн ажиллуулсан.

Хүнс, хөдөө аж ахуйн газрын бүтэц орон тоо

Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга	Р.Зоригт	2005 оноос
Хүнс, хөдөө аж ахуйн газрын орлогч дарга	Ш.Гантөмөр	2005-2006
Хүнс, хөдөө аж ахуйн газрын орлогч дарга	Б.Энхболд	2006-2008
Хүнсний хэлтсийн дарга	Д.Наранцэцэг	2005-2008
Эрчимжсэн мал аж ахуйн хэлтсийн дарга	Ж.Санжмятав	2005 -2008
Газар тариалангийн хэлтсийн дарга	Ц.Төмөртулга	2005-2008
НХХААГ-ын ня-бо	Б.Цэрмаа	2005-2008
НХААГ-ын ня-бо	Ж.Цэдэнсодном	2009 оноос

тус тус хариуцан ажиллаж байна.

Нийслэлийн хүнс, хөдөө аж ахуйн газар хувийн хэвшлийн хүнсний жижиг дунд олон үйлдвэрүүд, хөдөө аж ахуйн фермерийн аж ахуйнууд ажиллаж нийслэлийн хүн амыг олон нэр төрлийн эрүүл хүнсээр хангах хариуцлагатай үүргийг хүлээж байна.

Нийслэл хотын мал 2005 онд 247,1 мянган толгойд хүрч бүхэлдээ хувийн хэвшилд харъяалагдаж байна. Нийслэл хотод 2005 оны байдлаар талх, чихэр, нарийн боовны 317, мах боловсруулах 106, сүү цагаан идээ боловсруулах 92, архи, пиво, спирт, ундаа, цэвэр усны 123, гурилын 33 үйлдвэрүүд ажиллаж хөдөө аж ахуйн чиглэлээр сүүний фермерийн аж ахуй 74 ажиллаж гахайн аж ахуй 5, шувууны аж ахуй 7, төмс, хүнсний ногооны аж ахуй 76 ажиллаж байна.

Эдгээр аж ахуйнууд 2005 онд 18092,0 тн талх 5960,9 тн нарийн боов, 122,0 тн чихэр, 866,2 тн гоймон, 44,3 тн пүнтүүз, 2318,1 тн мах махан бүтээгдэхүүн, 26,6 сая литр сүү, 3343,5 литр архи, 7981,2 литр пиво, 2526,5 тн амтат ус, ундаа, 445,1 тн спирт, 7783,8 тн цэвэр ус, рашаан, 12,7 сая ширхэг өндөг, 24,5 тн шувууны мах, 34,9 тн гахайн мах, 5194,4 тн төмс, 3621,3 тн хүнсний ногоо үйлдвэрлэн нийслэлийн хүн амын хүнсний хэрэгцээнд нийлүүлж нийслэл хот жилийн хэрэгцээт хүнсний бүтээгдэхүүнийхээ 5-35,2 хувийг өөрийн үйлдвэрлэлээр хангадаг болжээ.

Нийслэлийн төр захиргааны байгууллагаас хөдөө аж ахуй болон хүнсний бүтээгдэхүүнийг аль болохоор эх орны үйлдвэрлэлээр хангах, импортыг эрс багасгах, экологийн цэвэр мах, сүү, төмс, хүнсний ногоо болон хүнсний бусад бүтээгдэхүүний үйлдвэрлэл хангамжийг нэмэгдүүлэх алс хэтийн бодлогыг ХХААХҮЯ-тай хамтран боловсруулан хэрэгжүүлэх явдал өнөөгийн тулгамдсан зорилт болоод байна.

Үүний тулд:

- Хотын мал сүрэгт бруцеллёз, сүрьеэ өвчний шинжилгээ явуулж эрчимжүүлэх замаар экологийн цэвэр, эрүүл мах, сүүгээр ард иргэдээ хангах
- Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлж мал аж ахуйд мал бордож таргалуулах, сүүний хагас бэлчээрийн маллагаатай эрчимжсэн фермерийн аж ахуйнуудыг олноор байгуулж тэдгээрт эцсийн бүтээгдэхүүн боловсруулдаг болгож малын ашиг шимийг сайжруулах ариун цэврийн магадлан шинжилгээний ажлыг боловсронгуй болгох, мал эмнэлэг, хорио цээрийн хяналтыг чангатгах, ажлыг цаг алдалгүй зэрэгцүүлэн зохион байгуулж үр дүнд хүргэх

- Газар тариаланг байгаль цаг уурын нөлөөллөөс бүрэн гаргаж усалгаатай болон хамгаалагдсан хөрсний ногооны аж ахуйг далайцтай хөгжүүлэх бодлого барьж, орчин үеийн ололт амжилт, шинэ технологи, механикжилт, автоматжуулалтыг өргөн нэвтрүүлэх
- Төмс, хүнсний ногоо хадгалах орчин үеийн механикжсан зоорь агуулахыг олноор барих хувийн хэвшлийн хүнсний үйлдвэрүүдийн үйлдвэрлэлийн байр, бүтээгдэхүүнд эрүүл ахуй, чанар, стандартчилалын аттестатчилалыг тогтмол явуулж чанарын баталгаатай стандартын эрүүл хүнсээр хүн амыг хангах
- Эх орны үйлдвэрлэлийн өндөг, гахай шувууны махаар нийслэлийн хүн амын хүнсний хэрэгцээг хангах бодлого барьж гахайг мах-өөхний, махны, шувууг өндөг, махны чиглэлээр үржүүлж, энэ чиглэлийн аж ахуйнуудыг дэмжиж хөгжүүлэх
- Улаанбаатар хот орчмын болон нийслэлийн хүнс, хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх хууль эрх зүйн болон санхүүгийн тааламжтай нөхцлийг бүрдүүлж мал аж ахуй, газар тариалан, хүнсний үйлдвэрүүдийн хөгжлийг дэмжиж урт хугацаатай, хүү багатай зээл олгох, газрын болон үндсэн хөрөнгө, орлогын албан татварыг аль болох хөнгөвчилөх, техник тоног төхөөрөмж авахад нь урт хугацаатай лизингийн үйлчилгээ үзүүлэх зэрэг бодлогыг барьж хэрэгжүүлэх

Нийслэлийн төр, захиргааны байгуулагаас хүн амынхаа өсөн нэмэгдэж байгаа хүнсний хангамжийн асуудлыг ямагт байнгын анхааралдаа байлгаж ард иргэдээ экологийн цэвэр эрүүл хүнсээр хангахад хотын хүнс, хөдөө аж ахуйн салбарын хөгжлийг эрчимжүүлэх явдал шийдвэрлэх ач холбогдолтой юм.

Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн 68 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2009 оны 14 тоот захирамжаар тус байгууллагад бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтөөр Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг **Хөдөө Аж Ахуйн Газар** болсон. Дотроо 2 хэлтэстэй

- Эрчимжсэн мал аж ахуйн
- Газар тариалангийн

Нийт 15 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажил үүргээ гүйцэтгэх байна.

Хүнсний хэлтсийн ажил үүргийг Улаанбаатар хотын Захирагчын ажлын албаны Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтэс хариуцан гүйцэтгэхээр болов.

Газрын орлогч дарга	Д.Нацагдорж	2012.10.01-ээс
Газар тариалангийн хэлтсийн дарга	Б.Батхүү	2009 оноос
Эрчимжсэн мал аж ахуйн хэлтсийн дарга	Д.Баярсайхан	2009 оноос
Ня-бо	Ж.Цэдэнсодном	2009 оноос

тус тус томилогдон ажиллаж байна.

Газар тариалангийн хэлтэст:

Хөрс ургамал хамгаалал, агропарк, ХАА–н үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх үйлчилгээ хариуцсан мэргэжилтэнээр Б.Энхболд 2009- 2010 онд ажилласан. 2010 оноос мэргэжилтэн Я.Сарансүх хариуцан ажиллаж байна.

Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэнээр Ц.Тунгалаг, жимс, жимсгэнэ хамгаалагдсан хөрсний үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэнээр Ц.Төмөртоогоо, усжуулалт, ХАА-н эдэлбэр газрын ашиглалт хариуцсан мэргэжилтэнээр Ц.Төмөртулга нар ажиллаж байна.

Эрчимжсэн мал аж ахуйн хэлтэст:

Хэлтсийн даргаар Д.Баярсайхан

Үйлдвэрлэл технологи хариуцсан мэргэжилтэнээр Н.Лхагвасүрэн

Гахай, шувуу, туслах аж ахуй хариуцсан мэргэжилтэнээр Ц.Баярмаа

Мал үржлийн ажил үйлчилгээ хариуцсан мэргэжилтэнээр Ж.Санжмятав

Уст цэг, тоног төхөөрөмж хариуцсан мэргэжилтэнээр У.Өнөржаргал нар ажиллаж байна.

ХАА-н газар нь өмчийн бүх хэлбэрийн хуулийн этгээд болон өөрийгөө бүрэн тэтгэх чадвартай аж ахуйд тулгуурласан, байгаль, цаг уурын өөрчлөлтөнд зохицсон, Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөө, газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан эрчимжсэн мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Бүс нутгийн хэмжээнд эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх ажлыг зохион байгуулж, мал аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт, дэвшилтэт технологийг нэвтрүүлэн, малын үүлдэрлэг байдлыг сайжруулж, нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх замаар өндөр ашиг шим бүхий зохистой тооны мал сүргийг мал аж ахуй эрхлэхийг зөвшөөрсөн бүсэд үржүүлэхэд /фермерийн аж ахуйг хөгжүүлэхэд/ дэмжлэг үзүүлэх. Нийслэлд мал аж ахуй эрхлэж буй иргэд аж ахуйн нэгж, байгууллагын оролцоотойгоор хадлан, тэжээл бэлтгэлийн хэмжээ, нэр төрлийг

нэмэгдүүлэн байгалийн болзошгүй эрсдэлээс мал сүргийг хамгаалах ажлыг зохион байгуулах.

- Нийслэлд төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний усалгаатай тариаланг хөгжүүлж, өрх, фермерийн аж ахуй болон жижиг хоршоод хамгаалагдсан хөрсний аж ахуйг эрхлэхэд дэмжлэг үзүүлэх.

- Мал аж ахуй, газар тариалан эрхлэхэд зайлшгүй шаардлагатай худаг, уст цэг, услалтын системийн хангамжийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх.

- Хөдөө аж ахуйн бодлогын асуудлаар хөтөлбөр, төсөл, чухал ач холбогдолтой бусад асуудал боловсруулан Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулж, хэрэгжилтийг хангах.

-Хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэлийн бүтээмж, үр ашгийг дээшлүүлэх, мал сүрэг, тариалангийн үйлдвэрлэлийг байгалийн гамшгаас хамгаалах даатгалын тогтолцоог боловсронгуй болгох, мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдийг хөрөнгө оруулалт, зээл татварын бодлогоор дэмжих чиглэлээр хууль, эрх зүйн орчинг шинэчлэх асуудлыг боловсруулах, холбогдох байгууллагуудаар шийдвэрлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх зэрэг ажлыг зохион байгуулдаг.

Мал аж ахуйн салбарт хийгдэж буй ажил: Малын чанар сайжруулах ажлыг бодлогоор тодорхойлж, нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх зорилгоор сүүний чиглэлийн үнээг зохиомол хээлтүүлэгт хамруулах, мал сүрэгт ангилалт хийх, сүүн ашиг шимийн түвшин тогтоож цаашид авах арга хэмжээний бодлого тодорхойлж, гойд ашиг шимт малыг үзэсгэлэн, дуудлага худалдаанд оруулах, цөм сүргийн аж ахуй байгуулах, мал сүргийг бүртгэл судалгаанд хамруулж улсын мэдээллийн санд оруулах, малын тэжээл бэлтгүүлэх, эрчимжсэн мал аж ахуй хөгжүүлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлэх зэрэг ажлуудыг зохион байгуулж байна.

Малын удмын сангийн үндэсний төвтэй хамтран үнээний зохиомол хээлтүүлгийн ажлыг зохион байгуулж байна.Нийслэлийн хэмжээнд 2005 оноос хойш 3185 үнээг зохиомол хээлтүүлэгт хамруулсан байна. Энэ ажилд мал үржлийн техникч Х.Очирбат, Ч.Батчимэг, Д.Жаргалсайхан, Б.Цэдэнсодном, Д.Хишигсүрэн, Х.Төмөрхуяг, М.Мөнхжаргал, Н.Наранцэцэг нар мэргэжлийн ур чадвар, идэвхи зүтгэл гаргаж ажиллаж байна.

Нийслэлийн нутаг дэвсгэрт сүүний үхэр, гахай, шувууны аж ахуйг эрчимжсэн хэлбэрээр хөгжүүлэх бодлого барьж жил бүр олон тооны иргэн, аж ахуйн нэгжийг хөнгөлөлттэй зээлийн төсөл хөтөлбөрт хамруулж аж ахуйгаа хөгжүүлэхэд мөнгөн зээл болон ашиг шимийн түвшин нь тогтоогдсон тодорхой тооны мал олгох зэрэг

дэмжлэг туслалцаа үзүүлж байна. Мал бүртгэх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх тухай журмыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд. Дүүргүүдэд ажиллаж байгаа 19 мал эмнэлэг, үржлийн үйлчилгээний нэгжүүдэд 58300 ширхэг гэрчилгээ, ээмэг, холбогдох багажийг хувиарлан олгов. Энэ ажлыг хэрхэн гүйцэтгэх талаар дүүргүүдэд ажиллаж байгаа малын эмч нарын нэгдсэн сургалтыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Мал эмнэлэг, үржлийн газар, Нийслэлийн мал эмнэлгийн газруудтай хамтран зохион байгууллаа. Мал ээмэглэж бүртгэлжүүлэх ажлыг Нийслэлийн 9 дүүргийн 19 мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүд мал 39,0 мянган үхэр ээмэглэж бүртгэлжүүлэх ажлыг хийгээд байна.

Сүүний чиглэлийн үхэрт хувьсийн ангилалтыг сүүлийн 4 жил дараалан хийж 1387 үхэр хувьсийн ангилалтанд хамрагдсан байна. Нийслэлд 207 үхэр бүхий цөм сүргийн 3 аж ахуй ажиллаж байна.

Дээрхи ажлуудын үр дүнд 2011 оны байдлаар сүүний үхрийн хоногийн дундаж саам улсын дундажаас 0,8 литрээр нэмэгдсэн, сүүний үйлдвэрүүд болон борлуулалтын цэгүүдээр дамжуулан жилд 38,4 сая литр сүүг нийслэлийн хүн амын хэрэгцээнд нийлүүлж байна.

Улсын үзэсгэлэнд оролцуулсан мал нь ашиг шимийн түвшингээрээ дээгүүрт орж жил бүр номинацын болон алт, мөнгө, хүрэл медалуудын болзол хангаж байр эзэлсэн байна.

Иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд нийслэлийн нутаг дэвсгэр дээр 278,9 мянган толгой мал, 415,0 мянган шувуу, 11,0 мянган гахай өсгөн үржүүлж жилд 38,0 сая литр сүү, 5,6 мянган тонн мах, 30,0 сая ширхэг өндөг үйлдвэрлэж нийслэлийн хүн амын хүнсний хэрэгцээнд нийлүүлж байна.

Мал аж ахуйн салбарт амжилттай ажиллаж байгаа иргэн, аж ахуйн нэгжүүдийн ажлыг жил бүр дүгнэж улсын болоод, нийслэлийн тэргүүнээр шалгаруулж байна. Үүнд:

Улсын сайн малчнаар:

- 2006 онд Баянзүрх дүүргийн 20-р хорооны иргэн Н.Даваа
- 2010 онд Багануур дүүргийн 4-р хорооны иргэн Б.Шаравдорж нар тус тус шалгарсан байна.

Улсын тэргүүний фермерээр:

- 2010 онд Хан-Уул дүүргийн 13-р хорооны иргэн Т.Дэмбэрэл

Нийслэлийн сайн малчнаар:

- 2006 онд Багануур дүүргийн 3-р хорооны иргэн Д. Одсүрэн
- 2007 онд Хан-Уул дүүргийн 13-р хорооны иргэн Т.Дэмбэрэл, Сүхбаатар дүүргийн 7-р хорооны иргэн Ц.Ишдорж

- 2008 онд Сонгинохайрхан дүүргийн 21-р хорооны иргэн Т.Лхайжав, Налайх дүүргийн 3-р хорооны иргэн Ч.Төөрүүл
- 2009 онд Налайх дүүргийн 1-р хорооны иргэн Б. Энхтөр, Багануур дүүргийн 4-р хорооны иргэн Б. Шаравдорж нар тус тус шалгарсан байна.

Нийслэлийн тэргүүний фермерээр:

- 2010 онд Сонгинохайрхан дүүргийн 21-р хорооны иргэн Н.Баянжав, Хан-Уул дүүргийн 13-р хорооны иргэн Д.Норовням, Налайх дүүргийн 4-р хорооны иргэн Б.Хүрэлтогоо
- 2011 онд Сонгинохайрхан 21-р хорооны иргэн П.Сосор, П.Баярмагнай, Хан-Уул дүүргийн 13-р хорооны иргэн фермер Ж.Болд, Хан-Уул дүүргийн 13-р хорооны иргэн Б.Туул
- 2012 онд БЗД-ийн 20-р хороо Г. Доржбат саалийн үхрийн аж ахуйгаар, ХУД-ийн 13-р хороо шувуучин фермер Б. Гантулга, СХД-ийн 20-р хороо гахайчин фермер М. Золзаяа нар тус тус шалгарсан байна.

Газар тариалангийн салбарт хийгдсэн ажил: Монгол улсын Засгийн газрын 2008 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 70 дугаар тогтоолоор “Атрын гурав дахь аян” тариалангийн хөгжлийн үндэсний хөтөлбөрийг батласан. Уг хөтөлбөрийн хүрээнд Засгийн газрын 2008 оны 136 дугаар тогтоолоор “Агропарк” төслийг хэрэгжүүлж Нийслэлийн 8 дүүрэгт агропарк байгуулж дуслын усалгааны системтэй 20*6 хэмжээтэй хүлэмж, ХУД, СБД, Налайх дүүрэгт бага оврын трактор тус бүр 1 ширхэгийг хүлээлгэн өгч агропаркууд үйл ажиллагааг явуулж байна.

Нийслэлийн газар тариалангийн салбарт усалгаатай тариалангийн болон хамгаалагдсан хөрсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, эрчимжүүлэх, шинэ техник, технологи, сортыг нэвтрүүлэх, гадаадын зээл тусламжийг өргөн ашиглах, өрхийн аж ахуй эрхлэгчдийг дэмжих, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх зэрэг ажлуудыг хийж байна. 1997 онд батлагдсан “Ногоон хувьсгал” үндэсний хөтөлбөр (I үе шат) амжилттай хэрэгжин дуусч байна. Хөтөлбөрийн хүрээнд 1998-2004 онд улсын төсөв, гадаад орнуудын буцалтгүй тусламжийн хөрөнгөөс нийт 1.77 тэрбум төгрөг зарцуулан бага оврын 225 трактор иж бүрдлийн хамт, 210 га талбай услах бороожуулагч төхөөрөмж, 42200 м² талбай бүхий 320 ширхэг хүлэмж, 660 га талбайг хамгаалах торон хашаа, хүнсний ногоо тарих, арчлах иж бүрдэл 300 гаруй багаж зэрэг техник, тоног хэрэгслийг 2000 гаруй өрх, агропаркад хөрөнгө оруулалтаар болон хөнгөлөлттэй үнээр хуваарилан олгож үйл ажиллагааг нь өргөжүүлэхэд дэмжлэг үзүүллээ. 2003 онд улсын хэмжээгээр 14.3 мянган га талбайгаас 138.2 мянган тонн төмс, хүнсний ногоо хураан авсан нь хөтөлбөр анх

батлагдсан 1997 оноос 50.1 мянган тонноор буюу 56.6 хувиар нэмэгдэж, ногооны үйлдвэрлэл эрхэлж байгаа өрхийн тоо 1997 оноос 2.5 дахин өссөн байна.

Нийслэлийн иргэдийн төмс, хүнсний ногооны тариалалтыг дэмжих, түүний үр дүнгээр төмс, хүнсний ногооны дотоодын хангамжийг нэмэгдүүлсэн байдал: Төмс, хүнсний ногоо тариалах зориулалтаар Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт Тарвагатайн аманд 200,0 га газрыг Нийслэлийн Засаг даргын 357 тоот захирамжаар Нийслэлийн хөдөлмөрийн газарт бүртгэлтэй 6 дүүргийн ажилгүй иргэдийн 40 бүлгийн 800 өрх, нийслэлийн иргэдэд үйлчилгээ үзүүлдэг 53 аж ахуйн нэгжийн 3500 өрхөд олголоо.

Монгол улсын Засгийн газрын тогтоолоор батлагдсан “Нийслэлд мал аж ахуй эрхлэх талаар баримтлах бодлого” хөтөлбөр, “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөр”, “Малын чанар сайжруулах хөтөлбөр”, “Малын тэжээл хөтөлбөр”, “Улаанбаатар бүсийн хөгжил” хөтөлбөр, “Агропарк” төсөл, “Ногоон хувьсгал” үндэсний хөтөлбөр, “Чацаргана” хөтөлбөр зэрэг мал аж ахуй, газар тариалангийн чиглэлийн олон хөтөлбөрүүд нийслэлд хэрэгжиж байна.

Газар тариалангийн салбарт амжилттай ажиллаж байгаа иргэн, аж ахуйн нэгжүүдийн ажлыг жил бүр дүгнэж улсын болоод, нийслэлийн тэргүүнээр шалгаруулж байна. Үүнд:

Нийслэлийн тэргүүний тариаланч хамт олноор:

- 2007 онд Хан-Уул дүүргийн 13-р хороо “Авдрын уулын гол овоо” ЗБН
- 2008 онд Баянгол дүүргийн 20- хороо “Дөрвөн түшиг” ХХК
- 2009 онд Сонгинохайрхан дүүргийн 21-р хороо “Өгөөж хайрхан” ХХК
- 2010 онд Сүхбаатар дүүргийн 14-р хороо “Агро сургалт” хоршоо 2011 ОНД Хан-Уул дүүргийн “Шимт газар” ХХК тус тус шалгарсан байна.

Нийслэлийн тэргүүний тариаланчаар:

- 2006 онд Баянгол дүүргийн 20-р хорооны иргэн Я.Оюунчимэг
- 2007 онд Хан-Уул дүүргийн 13-р хорооны иргэн Т.Улаанбаатар
- 2008 онд Хан-Уул дүүргийн 13-р хорооны иргэн С.Чүлтэм
- 2009 онд Багануур дүүргийн 3-р хорооны иргэн Ч.Юра
- 2010 онд Баянзүрх дүүргийн 20-р хорооны иргэн Ц.Отгонбаяр, Сүхбаатар дүүргийн 14-р хорооны иргэн Ц.Баттулга
- 2011 онд Сонгинохайрхан дүүргийн 25-р хорооны тариаланч Н.Цэдэнбал, Хан-Уул дүүргийн 13-р хорооны тариаланч П.Пүрэвдорж нар тус тус шалгарсан байна. Нийслэлийн Хөдөө аж ахуйн газраас мал аж ахуй, газар тариалангийн салбарт төр засгийн бодлого шийдвэрийг бүрэн хэрэгжүүлэх ажил үйлчилгээ үзүүлж ажиллаж байна.

2011 онд нийслэлийн хэмжээнд төмс 516,6 га-д тариалж 6380.22 тн, хүнсний ногоо 581.8 га-д тариалж 8806.3 тн, жимс жимсгэнэ 250.81 га-д тариалж 145.3 тн, нийт 1349.2 га-гаас 15331.82 тн ургац хураан авсан нь жилийн хэрэгцээнийхээ 11.5%-ийг хангасан бол 2012 оны 10 дугаар сарын 19-ны байдлаар төмс 597.73 га-д тариалж 5770.1 тн, хүнсний ногоо 476.4 га-д тариалж 5724.2 тн ургац аваад байна.

Хоёр. ХӨМРӨГИЙН ТҮҮХ

Тус байгууллага нь анх Хотын архивт 1995 оны 01 дүгээр сарын 14-ны өдөр хөмрөг үүсгэсэн байна. Акт бүртгэлээс үзэхэд анх 1976-1993 оны 218 ХН шилжүүлсэн ба тус архивт 1996 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн баримтанд ЭШТБ хийж 1996 оны 12 дугаар сарын 20-ны өдөр дуусан фондод хүлээлгэн өгсөн байна. ЭШТБ-ын ажлын явцад ихэнх баримт түр хадгалах байсан учир устгаж байнга хадгалах 88 ХН-д үлдсэнийг Хүнс, хөдөө аж ахуйн газрын бичиг хэрэг болон Улаанбаатар хотын улсын архивын фондч Л.Долгор нар акт бүртгэлээр хүлээлцжээ.

Ийнхүү 1996 оны 12 дугаар сарын 20-нд Хүнс, хөдөө аж ахуйн газрын хөмрөг нь хотын архивын 32-р хөмрөг болон үүссэн байна. Баримтын бүрдлээс үзэхэд 1978 оноос 1986, 1989-1996 оны тушаалтай ба 1987, 1988 оны тушаал дутуу байна. Мөн жилийн ажлын төлөвлөгөө, тайлан нь 1987 онд мөн 1991, 1993-1996 онуудад дутуу ирсэн байна.

Мөн тус хөмрөгийн баримтанд байнга хадгалахаас гадна түр хадгалах баримт хадгалагддаг ба 1992-1997 оны 31 ХН хадгалагддаг байна.

Одоогоор Нийслэлийн Архивын газар тус хөмрөгийн баримтыг 1-р хадгаламжийн санд хадгалдаг бөгөөд архивын баримтыг “Лавлагаа мэдээлэл олгох журам”-ын дагуу ашиглуулж байна.

Тус газар нь 1997 онд татан буугдсан бөгөөд 2005 онд дахин байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж эхлээд байна. Энэ хугацаанд зохион байгуулалтын нэгж, мэргэжилтэнүүдээс хадгаламжийн нэгжийг бүрдүүлэн хүлээн авч одоогоор 2005-2008 оны нийт 153 хадгаламжийн нэгж хадгалагдаж байна. Үүнээс:

- байнга хадгалах 67
- түр хадгалах 70
- 70 жил хадгалах 10
- гэрэл зургийн 6 баримт байна.

Ингээд тус газрын 2005-2008 оны архивын баримтанд 2009 оны 07 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн “Эрдэм шинжилгээ техник боловсруулалт” –ын ажлыг хийж 30-ны өдөр дууссан байна. Уг ЭШТБ-ын ажлыг тус газрын тогтоол шийдвэр, дотоод ажил, архив, бичиг хэрэг хариуцсан мэргэжилтэн хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Баримт бичгийг шинэчилсэн жагсаалтын дагуу байнга, түр болон 70 жил хадгалах баримтаар ангилах
- Хадгаламжийн нэгж болгон баримтыг үдэж хавтаслах

- Баримтын хуудас дугаарлах, нүүр бичилт болон баталгаа хийх, нуруу цаас наах зэрэг техник ажилбарыг хийх
- Лавлагаа мэдээллийн ач холбогдолтой болон хадгалах хугацаа дууссан баримтыг ялгаж устгах бичгийн түүвэр жагсаалтыг үйлдэх
- Хадгаламжийн нэгжид дугаар өгөх
- Байнга, түр, 70 жил хадгалах баримтын данс, бүртгэл жагсаалт зэргийг хийх

Архивын баримтыг тус газар үүсгэн байгуулагдаснаас хойш бүгдийг заавар журмын дагуу үдэж хавтаслан байнга, түр хадгалах баримтуудыг тус тусд нь ангилан төрөлжүүлж эмх цэгцтэй хадгалаж ирсэн.

2005-2007 оны даргын тушаалыг 2008 онд гарсан “Байгууллагын үйл ажиллагаанд үүссэн удирдлагын нийтлэг баримт бичгийн хадгалах хугацааны үлгэрчилсэн жагсаалт”-ын дагуу үндсэн үйл ажиллагааны чиглэлээр болон боловсон хүчний чиглэлээр гаргасан гэсэн үндэслэлээр ангилан тус бүрт хадгаламжийн нэгжийн товъёог бичсэн болно. Мөн 2005-2007 он санхүүгийн баримтанд ажиллагсадын цалин болон НДШ, ЭМД тооцоог ангилан авч 70 жил хадгалах хадгаламжийн нэгж болгон товъёог бичсэн болно.

Эрдэм шинжилгээ техник боловсруулалтын үр дүнд:

Байнга хадгалах 67 хадгаламжийн нэгж, түр хадгалах 70 хадгаламжийн нэгж, 70 жил хадгалах 10 ХН, гэрэл зургийн 6 баримт, устгах хэргийг ялган данс, бүртгэл, актыг тус тус үйлдэн Нийслэлийн Архивын дэргэдэх ББНШАЗК-ын хурлаар батлуулахаар оруулсан.

2009 онд дөрвөн жилд нэг удаа явагддаг “Архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагуудын ажлын зохион байгуулалт” -ын улсын үзлэг явагдахтай холбогдуулан ажлын хэсэг байгуулан, ажлын төлөвлөгөө гарган ажилласан.

Улсын үзлэгээр 93 буюу “А” үнэлгээ авсан ба Архивын үйл ажиллагаагаар “Загвар” байгууллага болон шалгарч Нийслэлийн Засаг даргын батламж мөнгөн шагналаар шагнуулсан.

Улсын үзлэгтэй холбогдуулан байгууллагын архивт газрын даргын тушаалаар ажлын хэсэг томилогдон тоолого явуулж дүн мэдээгээ хугацаанд нь гарган удирдлагад танилцуулсан.

Улсын үзлэгтэй холбогдуулан газрын даргын 2009 оны 8–р сарын 24-ны өдрийн 23 тоот тушаалаар комисс томилогдон тус газрын архивын баримтанд 2009 оны 8 дугаар сарын 24-ны өдрөөс 25-ны хооронд тоолого явуулж дүн мэдээгээ хугацаанд нь гарган удирдлагад танилцуулсан.

Комиссын бүрэлдэхүүн:

Комиссын дарга: Газар тариалангийн хэлтсийн дарга Ч.Батхүү
/албан тушаалын нэр, овог, нэр/

Гишүүд Эрчимжсэн мал аж ахуйн хэлтсийн мэргэжилтэн
Ц.Баярмаа

Тогтоол шийдвэр, дотоод ажил, архив, бичиг хэрэг
хариуцсан мэргэжилтэн Ж.Содцэцэг нарын оролцсон.

Тооллогоор:

- Байнга хадгалах 67 ХН
- Түр хадгалах 70 ХН
- 70 жил хадгалах 10 ХН
- Гэрэл зургийн баримт 6 ХН тоологдсон.

Нийт 153 ширхэг хадгаламжийн нэгж тус газрын архивт хадгалагдаж байна.

Сэлбэн засах, ариутгах, сэлбэн засах боломжгүй болсон болон задгай баримт байсангүй. Түр ашиглуулахаар олгосон баримт, санхүүгийн 2007 оны 2 баримт, 2008 оны 5ш нийт 7 баримт байлаа. Хадгаламжийн нэгжүүдийг заавар журмын дагуу төмөр сейфэнд байнга, түрээр нь ангилан хадгалж байна.

Мөн 2011 онд нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, тэдгээрийн харъяа байгууллагууд Улаанбаатар хотын Захирагчийн харъяа газруудын хэмжээнд архивын баримтанд нэгдсэн тооллого явуулах захирамж гарсаны дагуу ажлын хэсэг байгуулан ажиллаж тайлан, мэдээг хугацаанд нь гаргаж нийслэлийн Архивын газарт хүргүүлсэн.

Тооллогоор

- Байнга хадгалах 108 ХН
- Түр хадгалах 99 ХН
- 70 жил хадгалах 10 ХН

Нийт 217 ХН тус газрын архивт хадгалагдаж байна. Үүнээс хадгалах хугацаа дууссан 11 хадгаламжийн нэгжийг устгах бүртгэлд авав.

Эрдэм шинжилгээ техник боловсруулалтын үр дүнд:

Байнга хадгалах 108 хадгаламжийн нэгж, түр хадгалах 99 хадгаламжийн нэгж, 70 жил хадгалах 10 ХН, гэрэл зургийн 10 баримт, устгах хэргийг ялган данс, бүртгэл, актыг үйлдсэн.